

Үнэнийг хэлэх

Та манай Сахилгын дүрэм, Байгууллагын ёс зүй, хууль зөрчигдсөн гэж сэжиглэж байвал эсвэл санаа зовоосон асуудал байгаа бол таныг үнэнийг хэлээсэй гэж бид хүсэж байна.

Бид нээлттэй байхыг зорьдог бөгөөд санаа зовоосон асуудал буруу байсан ч гэсэн тэдгээрийг гаргасан хүмүүсийг ойлгон дэмждэг. Гэхдээ хорон санааны үүднээс гаргасан санаа зовоосон асуудал нь сахилгын арга хэмжээ авахад хүргэж болно.

Манай Сахилгын дүрэм, Байгууллагын ёс зүй интранет дээр дараах хаягт бий: www.imperialbrandsplc.com. Та асуултуудаа Governance.Team@impbrands.com э-мэйл хаягаар явуулж болно

Үнэнийг хэлэх хэд хэдэн арга бий:

1. Дотоод түвшинд үнэнийг хэлэх

Хэрэв танд эвгүй биш бол та санаа зовоосон асуудлаа хүний нөөц хариуцсан менежер эсвэл хүний нөөцийн хамт олонтой ярилцаж болно.

2. Группт үнэнийг хэлэх

Хэрэв танд хамт ажилладаг хүнтэйгээ санаа зовоосон асуудлаа ярилцахад тухгүй эсвэл санаа зовоосон асуудлаа дотоод түвшинд хэлсэн ч өгсөн хариуд сэтгэл хангалуун бус байгаа бол Группийн хэн нэгэнд хандах боломжтой, үүнд:

- **Групп Компанийн нарийн бичиг;**
- **Группийн санхүүгийн удирдлага;** эсвэл
- **Группийн хүний нөөцийн дарга.**

Утас: +44 (0)117 963 6636 залгаад үнэнийг хэлэх гэсэн юм гэж хэлээрэй.

Хэрэв санаа зовоосон асуудлаа бичгээр мэдүүлэхийг илүүд үзэж байгаа бол болно. Энэ нь бид тантай эргээд холбогдоход тустай. Та санаа зовоосон асуудлаа дараах хаягаар э-мэйл эсвэл шуудангаар илгээж болно:

Групп Компанийн нарийн бичиг, 121 Winterstoke Road, Bristol, BS3 2LL, United Kingdom Тэмдэглэсэн: 'Хувийн'	Э-мэйл: speakup@impbrands.com .
---	--

3. Expolink-н гадаад дуудлага хүлээн авах утас ашиглан үнэнийг хэлэх

Та аль ч шатанд сонгож, утас, э-мэйл, вэб, The SpeakingUp апп зэргийг тусламжтай холбоо барьж болох **Expolink**-н бүрэн бие даасан үйлчилгээг ашиглан санаа зовоосон асуудлаа мэдүүлэх боломжтой. Үүнийг хүсвэл бүрэн нэрээ нууцлан хийх боломжтой. Expolink таны санаа зовоосон асуудлыг зөв хүмүүст нь хурдан шуурхай хүргэнэ:

- Expolink дуудлага хүлээн авах утас нь 7 хоногийн 24 цаг ажилладаг (гэхдээ Арванхоёрдугаар сарын 25-ны өдрөөс бусад үед). Тус утасны дугаар нь улс бүрт ялгаатай байна. Хэрэв та аль нь зөв дугаар болохыг мэдэхгүй байгаа бол байгууллагын дотоод зарлалын самбараас эсвэл дараах хаягаар орж харна www.expolink.co.uk, www.imperialbrandsplc.com эсвэл Группийн интранет
- Мэдээллийг imperialbrands@expolink.co.uk хаягаар Expolink рүү э-мэйлээр явуулж болно
- Вэбд тулгуурласан мэдээллийг 'imperialbrands' нэвтрэх код ашиглан Expolink-н www.expolink.co.uk вэб сайтаас илгээх боломжтой

- Apple App Store, Google Play, Microsoft зэргээс The SpeakingUp аппыг татаж авна уу. Нэвтрэх код 'imperialbrands'-г ашиглана уу.

Бид танд баталгаа гаргана

Бид чадах чинээгээрээ таны нэрийг нууцалж, таны зүгээс гаргасан санаа зовоосон асуудлыг чандлан нууцлана. Гэхдээ үнэн зөв мөрдлөг шалгалт явуулахад зарим мэдээллийг задруулах хэрэг гарч болзошгүй.

Та өөрийн ажиллаж байгаа улсын хуульд зөвшөөрөгдсөний дагуу санаа зовоосон асуудлаа нэрээ нууцлан ил болгож болно.

Бид үнэнийг хэлсэн эсвэл мөрдлөг шалгалтад тус болж буй хүнээс өш хонзон авахыг хүлцдэггүй.

2019 оны наймдугаар сар